



## НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Ачлахуй ӨЭМТ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/177/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор:  
Г.Нандинжаргал  
Утас: 7000-7734 Цахим хаяг: [nandinjargalg@audit.gov.mn](mailto:nandinjargalg@audit.gov.mn)  
Санхүү, аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр  
Утас: 11315558 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)  
Аудитын менежер: Я.Алтанцэцэг  
Утас: 11315558 Цахим хаяг: [altantsetseg.ya@audit.mn](mailto:altantsetseg.ya@audit.mn)  
Их наяд аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Х.Ариунзул  
Утас: 99077062 Цахим хаяг: [ikhnayadaudit@gmail.com](mailto:ikhnayadaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 837  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ  
ДҮҮРГИЙН АЧЛАХУЙ ӨЭМТ-ИЙН  
ДАРГА Д.БАТСҮРЭН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.4, Төсвийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Ачлахуй ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Ачлахуй ӨЭМТ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус төв нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж үйлчилгээ, оношилгоо шинжилгээ, өдрийн эмчилгээ гэсэн 4 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Ачлахуй ӨЭМТ нь 4 төрлийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлд Эрүүл мэндийн даатгалын сангаас нэг иргэнд ногдох зардлын санхүүжилтээр 851.2 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн ажилласан байна.

### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хяналт, санхүүжилт, төлбөр тооцооны программ, цахим системийг бодит цагийн горимд шилжүүлж, иргэнд чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чирэгдэлгүй үзүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн шинэчлэл хийгдсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Ачлахуй ӨЭМТ-ийн 2025 оны гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/145 захирамжаар 96.0 хувь, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ, худалдан авах даатгалын гэрээний биелэлтийг 100.0 хувийн хэрэгжилттэй гэж үнэлсэн байна.

Тус ӨЭМТ-ийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар бүтэц орон тоог 23-аар баталж үйл ажиллагаагаа явуулсан байна.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	-	-
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	5,489,117.92	10,644,012.45
Дансны авлага	68,692,588.16	10,013,681.90
Бараа материал	192,752,730.80	153,992,834.75
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>266,934,436.88</b>	<b>174,650,529.10</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	-	-
Үндсэн хөрөнгө	214,209,507.63	174,255,068.36
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>214,209,507.63</b>	<b>174,255,068.36</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>481,143,944.51</b>	<b>348,905,597.46</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	-	-
<b>Эзэмшигчдийн өмч</b>	-	-
Төрийн	61,329,549.76	61,329,549.76
Хувийн	230,650.00	230,650.00
Хуримтлагдсан ашиг	416,845,014.75	284,606,667.70
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,738,730.00	2,738,730.00
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>481,143,944.51</b>	<b>348,905,597.46</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>481,143,944.51</b>	<b>348,905,597.46</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>Борлуулалтын орлогын дүн</b>	<b>6,617,632.00</b>	<b>6,444,436.90</b>
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>6,617,632.00</b>	<b>6,444,436.90</b>
Санхүүжилтийн орлого	890,770,333.29	851,199,035.50
Хүүгийн орлого	57,674.70	33,591.68
Бусад орлого	31,941,417.40	8,418,205.81
Ерөнхий ба удирдлагын зардал	944,979,222.05	998,333,616.94
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(15,592,164.66)</b>	<b>(132,238,347.05)</b>
Орлогын татварын зардал	-	-
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(15,592,164.66)</b>	<b>(132,238,347.05)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	-
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	864,940,298.83	916,355,970.34
<b>Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн</b>	<b>864,940,298.83</b>	<b>916,355,970.34</b>
<b>Мөнгөн зарлагын дүн</b>	-	-
Ажиллагчдад төлсөн	597,005,180.00	644,021,253.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	65,526,768.17	72,400,473.07
Бараа материал худалдан авахад төлсөн	52,854,239.64	22,082,390.89
Ашиглалтын зардалд төлсөн	36,075,811.17	38,552,899.18
Бусад мөнгөн зарлага	142,466,114.13	132,864,159.67
<b>Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн</b>	<b>893,928,113.11</b>	<b>909,921,175.81</b>
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(28,987,814.28)</b>	<b>6,434,794.53</b>
<b>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ дүн</b>	-	-
<b>Мөнгөн орлогын дүн</b>	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн</b>	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	16,142,200.00	1,279,900.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн</b>	<b>16,142,200.00</b>	<b>1,279,900.00</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(16,142,200.00)</b>	<b>(1,279,900.00)</b>
<b>Санхүүгийн мөнгөн гүйлгээний дүн</b>		
<b>Мөнгөн орлогын дүн</b>		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
<b>Санхүүгийн мөнгөн орлогын дүн</b>	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
<b>Санхүүгийн мөнгөн зарлагын дүн</b>	-	-
<b>Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	-
<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(45,130,014.28)</b>	<b>5,154,894.53</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>50,619,132.20</b>	<b>5,489,117.92</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>5,489,117.92</b>	<b>10,644,012.45</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад цэвэр хөрөнгө/өмч	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>61,692,149.76</b>	<b>2,738,730.00</b>	-	<b>432,437,179.41</b>	<b>496,868,059.17</b>
Өмчит гарсан өөрчлөлт	(131,950.00)	-	-	-	<b>(131,950.00)</b>
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	-	-	(15,592,164.66)	<b>(15,592,164.66)</b>
<b>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>61,560,199.76</b>	<b>2,738,730.00</b>	-	<b>416,845,014.75</b>	<b>481,143,944.51</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>61,560,199.76</b>	<b>2,738,730.00</b>	-	<b>416,845,014.75</b>	<b>481,143,944.51</b>
Өмчит гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	-	-	(132,238,347.05)	<b>(132,238,347.05)</b>
<b>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>61,560,199.76</b>	<b>2,738,730.00</b>	-	<b>284,606,667.70</b>	<b>348,905,597.46</b>

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 1,704.9 мянган төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Кассын гүйлгээний журнал хөтлөөгүй, зарлагын ангиллыг буруу сонгож шууд зарлагадсан байна.	1	440.0			1	440.0	1	440.0				
2	Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвийн даргын 2025 оны 07 дугаар сарын 29-ны А/58 дугаар тушаалаа “Олон найрлагат бичил тэжээлийн Бэлдмэл”-ийг Үнэ төлбөргүй хүлээлгэн өгөхөд бүртгэж аваагүй байна.	1	1,264.9	1	1,264.9			1	1,264.9				
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,704.9</b>	<b>1</b>	<b>1,264.9</b>	<b>1</b>	<b>440.0</b>	<b>2</b>	<b>1,704.9</b>				

3.2 Аудитаар нийт 10,343.1 мянган төгрөгийн 4 зөрчил<sup>2</sup> илэрсэнд 10,343.1 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмж өгсөн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажилтанд зэргийн нэмэгдлийг ур чадварын нэмэгдлээр давхардуулан 2,218.8 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.	1	2,218.8	1	2,218.8				
Баянзүрх дүүргийн Эрүүл мэндийн төвийн 2025 оны А/65 тоот тушаалаар зөвхөн өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт олгогдох урамшууллыг нэр бүхий 6 ажилтанд тооцож 7,168.5 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.	1	7,168.5	1	7,168.5				
Хамаарал бүхий этгээдийг ажилд томилж 955.8 мянган төгрөгийн цалин олгосон байна	1	955.8	1	955.8				
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 70 нэр төрлийн /81,836.0 мянган төгрөгийн/ хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.	1	-					1	-
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>10,343.1</b>	<b>3</b>	<b>10,343.1</b>			<b>1</b>	<b>-</b>

**3.3** Аудитаар нийцлийн асуудлаар нийт 51,946.0 мянган төгрөгийн 4 зөрчил илэрсэнд 380.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 51,566.0 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүллээ.

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эм боох материалын арван сая төгрөгөөс дээш худалдан авалтын жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулаагүй, төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлээгүй байна.	1	30,566.0			1	30,566.0		

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Ачлахуй ӨЭМТ-ийн 2025 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Тушаал шийдвэрт хууль эрх зүйн үндэслэлийг буруу тусгаж 21,000.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.	1	21,000.0			1	21,000.0		
Тус өрх нь бэлэг дурсгалын зүйл худалдан авсан байна.	1	380.0	1	380.0				
Ажилтан, албан хаагчдын ажлын цаг ашиглалтын бүртгэлийг цаг бүртгэлийн цахим системээр бүртгээгүй, сарын эцэст ажилтны ажлын цагийн бүртгэлийг системээс хэвлэн авч баталгаажуулаагүй байна.	1	-			1	-		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>51,946.0</b>	<b>1</b>	<b>380.0</b>	<b>3</b>	<b>51,566.0</b>		